

УУЛ УУРХАЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ ШҮҮМЖ

“Хуулийн шүүмж”-ийн энэ удаагийн дугаарт Нээлттэй Нийгэм Форумаас зохион байгуулж буй Уул уурхайн тухай хуулийн төслийн цуврал хэлэлцүүлгийн нэг болох “Уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт” сэдэвт хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн нийтэлж байна. Уг хэлэлцүүлэгт хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн болон хэвлэл мэдээллийн ажилтнууд, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий 32 хүн оролцсон болно.¹

“Хуулийн шүүмж”-ийн өмнөх дугаарт “Ил тод байдал” сэдэвт хэлэлцүүлгийн саналыг нийтэлсэн бөгөөд дараагийн дугаараас “Тусгай зөвшөөрлийн үйл явц ба иргэдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийн саналыг хүлээн авна уу.

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

“Уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт” сэдэвт хэлэлцүүлгээр хуулийн төслийн 9 дүгээр бүлэг буюу “Байгаль орчин, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа, 11 дүгээр бүлэг буюу “Уурхай, уулын үйлдвэрийн хаалт”-тай холбоотой заалтуудыг авч хэлэлцлээ.

ХОЁР. ЕРӨНХИЙ САНАЛ ШҮҮМЖ

Хуулийн төсөлд уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлт, хаалтын эрх зүйн цогц зохицуулалтыг тусгасныг сайшаан дэмжиж байна. Ингэснээр өмнө нь эрх зүйн зохицуулалтгүй явж ирсэн уурхайн хаалттай холбоотой харилцааг хуульчилж, уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хуулийн төсөлд уурхай, уулын үйлдвэрлэл эрхлэх бэлтгэл ажлыг хангах (33.12 дэх хэсэг), уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулахад (53 дугаар зүйл) төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлж, орон нутгийн иргэдтэй зөвшилцөх шаардлагыг тусгасан нь сайшаалтай байна. Гэхдээ бизнесийн үйл ажиллагаанаас хүн амын эрүүл мэнд, нийгэм, соёл, хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлж, сөрөг нөлөөг бууруулах, арилгах эрх зүйн орчин Монгол улсад хараахан бүрдээгүй байгаа билээ. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийх аргачлал байхгүй, түүнийг хянан батлах субъект нь тодорхойгүй байгаа ийм нөхцөл зөвхөн үнэлгээ хийх төдий үүрэг оногдуулах зохицуулалт хангалтгүй юм.

Санал: Иймд уул уурхайн үйл ажиллагааны нийгмийн нөлөөллийн үнэлгээг хэн, хэрхэн хийх, шалган баталгаажуулах, хэрэгжилтийг хянах үйл явцыг цогцоор нь авч үзэж хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.

Тэрчлэн хуулийн төслөөр уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ), байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг нь хянах үйл явцыг бүхэлд нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрх хэмжээнээс салган Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдэлд шилжүүлэхээр тусгажээ. БОНБУ нь хөрс, ус, агаар, амьтан, ургамал зэрэг хүрээлэн буй орчны бүрдэл хэсэг тус бүрт үзүүлэх сөрөг нөлөөг нарийвчлан тогтооход чиглэсэн шинжлэх ухааны тусгай мэдлэг шаардсан нарийн түвэгтэй үйл ажиллагаа юм. Тэрчлэн хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, амьжиргааны хэв маяг нь дээрх үнэлгээний чанараас шууд хамааралтай. Ийм ч учраас үнэлгээний тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны олон мэргэжилтнүүд хянан магадалж, хэд хэдэн шат дамжлагаар хэлэлцэн баталдаг билээ. Харин тусгай мэдлэг, мэргэжил шаардах ийм чухал үйл явцыг мэргэжлийн бус буюу УУХҮЯ-ны эрх мэдэлд шилжүүлэх нь эцсийн дүндээ үнэлгээний чанарыг сулруулж, хүрээлэн буй орчин, нутгийн иргэдийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулах эрсдэлтэй юм. Нөгөөтэйгүүр хуулийн төсөлд байгаль орчны хууль тогтоомж, тэр дундаа Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуультай давхардсан, зөрчилдсөн заалтууд маш их байгаа нь ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэхээр байна.

Санал: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой харилцааг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулж буй өнөөгийн тогтолцоог хэвээр үлдээх нь зүйтэй.

Аливаа уул уурхайн төслийг түүний цар хүрээ, эрсдэлийн хэр хэмжээнээс хамааран эрсдэл ихтэй, дунд зэргийн эрсдэлтэй, эрсдэл багатай, бичил уурхай гэж ангилан техник, эдийн засаг, байгаль орчин, уурхайн хаалтын хувьд харилцан адилгүй шаардлага тавихаар тусгажээ. Гэхдээ төслийн цар хүрээ, эрсдэлийн хэмжээг хэн, хэрхэн тогтоох аргачлал, шалгуур үзүүлэлтийг орхигдуулсан нь тодорхойгүй байдал үүсгэж, хуулийн хэрэгжилтийг бүхэлд нь сулруулахаар байна.

Санал: Уул уурхайн төслийн цар хүрээ, эрсдэлийн хэмжээг тодорхойлох байгууллага, баримтлах шалгуур үзүүлэлтийг дээрх ангилал тус бүрээр нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Хуулийн төсөлд уурхай, уулын үйлдвэрийн “хаалтын комисс”, “хаалтын ажлыг хүлээн авах комисс” зэрэг өөр өөр бүтцийг тодорхойлсон боловч тэдгээрийн бүрэлдэхүүн, чиг үүргийн ялгааг нарийвчлан тодорхойлоогүйгээс давхардсан мэт ойлгогдож байна.

Санал: Ялгаатай чиг үүрэг бүхий хоёр өөр бүтэц байх шаардлагатай гэж үзэж байгаа бол үүрэг, хариуцлага, бүрэлдэхүүн, түүнийг байгуулах үйл явцыг хуулийн төсөлд нарийвчлан заах хэрэгтэй байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоог нэгтгэн тусгажээ. Гэхдээ уг зүйлд тусгагдсан эрх, үүрэг нь бүхэлдээ мэргэжлийн холбоодод чиглэсэн бөгөөд нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын оролцоог орхигдуулсан байна.

Санал: Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага нь зорилго, үйл ажиллагааны чиглэлийн хувьд эрс ялгаатай тул уурхай, уулын үйлдвэртэй холбоотой харилцаанд оролцох тэдгээрийн эрх үүргийг ялгаатай байдлаар хуульчлах.

Хуулийн төслийн 54.9-д эзэнгүй орхигдсон уурхайн хаалтын зардлыг хаалтын эрсдэлийн сангаас гаргахаар заажээ. Гэхдээ “эзэнгүй орхигдсон уурхай” гэж юуг ойлгох, тэр нь хаягдсан уурхайгаас хэрхэн ялгагдах нь тодорхойгүй байна.

Санал: “эзэнгүй орхигдсон уурхай” гэсэн ойлголтыг хуулийн төслийн томъёоны хэсэгт тусгаж өгөх

Эцэст нь хэлэхэд, хуулийн төслийн эх бичвэрт дүрэм, найруулга, дугаарлалт, нэр томъёоны алдаа маш их байна.

Санал: Хуулийн төслийн нэр томъёо, хэл, найруулгыг дахин сайтар нягталж, сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

ГУРАВ. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

Хуулийн төсөлд нэмэх заалт			
№	Зүйл хэсэг	Санал	Тайлбар үндэслэл
1.	8.6	“Нийгмийн нөлөөллийн үнэлгээний журам, аргачлал батлах” гэсэн заалт нэмэх	Хуулийн төсөлд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагыг тусгасан боловч түүнийг хэн, хэрхэн хийх, чанар, хэрэгжилтийг нь төрийн аль байгууллага хэрхэн хянах асуудлыг орхигдуулсан байна. Нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь эрүүл мэнд, эдийн засаг, нийгэм, соёл зэрэг олон асуудлыг хамарсан цогц үйл ажиллагаа болохын хувьд дээрх асуудлаар ажилладаг төрийн бүх байгууллагуудын хамтын ажиллагаа, хяналт, оролцоо чухал юм. Иймд нийгмийн нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газраас батлан гаргадаг байх нь зүйтэй.
2.	12.3	“Уурхай, уулын үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавих” гэсэн заалт нэмэх	Хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх үүрэг нь зөвхөн хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянахаар хязгаарлагдах учиргүй бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавьдаг байх ёстой.
3.	13.10	“Нийгмийн нөлөөллийн үнэлгээг 90 хоногийн дотор” гэсэн заалт нэмэх	Уурхай, уулын үйлдвэрлэл эрхлэгчийн нийгмийн нөлөөллийн үнэлгээг хянан батлах байгууллагыг тодорхой болгох шаардлагатай.
4.	14.2	“санал өгөх” гэсний өмнө “орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн” гэж нэмэх .	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн газрыг цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болохуйцаар нөхөн сэргээж хүлээлгэн өгөх үүрэгтэй. ² Иймд орон нутгийн захиргаа нь орон нутгийнхаа газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн уурхайн хаалтын төлөвлөгөөнд санал өгдөг байх нь зүйтэй.

5.	14.4	“Хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, хаалтын төлөвлөгөө зөрчигдсөн талаар дүгнэлт гаргуулахаар төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргах” гэсэн заалт нэмэх	Орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага нь хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд уул уурхайн компанийн хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авдаг байх ёстой.
6.	14.5	“уурхай, уулын үйлдвэрийн хаалтын комиссын бүрэлдэхүүнд орох” гэсэн заалт нэмэх	Хаалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, хаалтыг хүлээн авах үйл явцад тухайн орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын оролцоог хангах шаардлагатай.
7.	15	“Уурхай, уулын үйлдвэрлэл эрхлэгчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих, төлөвлөгөө зөрчигдсөн талаар дүгнэлт гаргуулахаар төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргах” гэсэн заалт нэмэх	Хаалтын төлөвлөгөөнд хөндлөнгийн хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах шаардлага гаргах төрийн бус байгууллагын эрхийг баталгаажуулах.
8.	15	“уурхай, уулын үйлдвэрийн хаалтын комиссын бүрэлдэхүүнд орох” гэсэн заалт нэмэх	Хаалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, хаалтыг хүлээн авах үйл явцад төрийн бус байгууллагын оролцоог хангах шаардлагатай.
9.	25.3	“зураг төслийн ажил эхлэхээс өмнө” гэсний дараа “тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд үндэслэн” гэж нэмэх	Газрын тухай хуулийн дагуу ³ далд уурхайн газар доорх барилга байгууламжийн байршлыг тогтооход тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харгалзан үзэх ёстой.
10.	41.2	“Тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө” гэсэн заалт нэмэх	Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйн байршлыг сонгоход тухайн орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг харгалзан үзэх нь зүйтэй.
11.	42.2	Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилчдыг тодорхой хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах” гэсэн заалт нэмэх	Хуулийн төсөлд эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой зааж өгч байгаа тохиолдолд мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах нь зүйтэй.
12.	52.4	“тодотгол” гэсний дараа “хэрэгжилтийн тайлан” гэж нэмэх	Хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан олон нийтэд ил тод байх ёстой.
13.	53.1	“Хаалтын дараа байгаль орчинд үргэлжлүүлэн нөлөө үзүүлэх байгууламжаас гүний усны чанар, хэмжээнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн нөлөөлөл үзүүлэхгүй болохыг нотолсон тооцоо, судалгаа” гэсэн заалт нэмэх	53.1.5-д заасан “физик, химийн тогтвортой байдлыг хадгалах” гэсэн ойлголтод усны түвшнийг зохих хэмжээнд хадгалах асуудал багтахааргүй байна. Иймд уурхайн талбай орчмын усан орчны тэнцвэрт байдлыг хадгалахтай холбоотой иж бүрэн тооцоо судалгааг хаалтын төлөвлөгөөнд тусгах шаардлагатай.
14.	53.1	“Далд уурхайн газар доорх барилга, байгууламжийн аюулгүй байдлыг хангах, бусад зориултаар ашиглах, нуралт цөмрөлтөөс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, зураг төсөл” гэсэн заалт нэмэх	Далд уурхайн онцлогоос хамаарсан онцлог зохицуулалтыг хаалтын төлөвлөгөөнд тусгах шаардлагатай.

15.	53.1.5	“арга хэмжээ” гэсний дараа “хаалтын бусад боломжит хувилбарыг судалсан тооцоо судалгаа” гэж нэмэх	Хаалтын үйл ажиллагааны боломжит бүх хувилбарыг харьцуулан судалж, хамгийн оновчтойг нь сонгон авсныг нотлох шаардлагатай.
16.	53.1.5	“физик, химийн тогтвортой байдлыг хадгалах” гэсний дараа “нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах” гэж нэмэх	Хаалтын төлөвлөгөөнд нийгэм, эдийн засгийн төлөв байдлын суурь үнэлгээ, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг тусгах шаардлагыг тавьсан байна. Ийнхүү нэгэнт нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийж байгаа тохиолдолд нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хаалтын төлөвлөгөөнд мөн тусгах нь зүйтэй.
17.	55.4	“Хаалтын санхүүгийн баталгаанаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлсөн тухай төрийн захиргааны байгууллагын шийдвэр олон нийтэд нээлттэй байна” гэсэн заалт нэмэх	Хаалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг баталгаажуулсан шийдвэрийг нийтэд ил тод байлгах нь тэдгээрийн хэрэгжилт, үнэн зөв байдалд олон нийтээс хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.

Өөрчлөн найруулах заалт

№	Зүйл заалт	Санал	Тайлбар үндэслэл
1.	13.12	“уурхай, уулын үйлдвэрлэлийн байгаль орчны мэдээллийн сан үүсгэж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хаалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, хаалт хийгдсэн, орхигдсон, хаалтын дараах хяналт шинжилгээнд буй уурхай, уулын үйлдвэрийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана” гэж өөрчлөх	Хуулийн төсөлд уул уурхайн төслийн БОНБУ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлан, хэрэгжилтэд хяналт тавихаар тусгасан байна. Иймд дээрх баримт бичгүүд болон нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хаалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилтийн тайланг нийтэд ил тод болгох үүргийг төрийн захиргааны байгууллагад оногдуулах нь зүйтэй.
2.	38.1	“Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн сонгосон технологи, тоног төхөөрөмж нь тухайн үйлдвэрт ашиглах түүхий эдэд тохирох эсэхийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн туршилтын үр дүнгээр баталгаажуулсан байна” гэж өөрчлөх	Хуулийн төслийн 38.2 дахь заалттай нэгтгэв.
3.	40.1	“Аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаандаа химийн хорт болон аюултай бодис ашиглаж байгаа бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд эрсдэлийн үнэлгээг хийлгэсэн байна” гэж өөрчлөх	Эрсдэлийн үнэлгээний үйл явцыг хуульд нэг бүрчлэн дурдах шаардлагагүй.

4.	46.2	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д заасан гэрээнд байгаль орчныг нөхөн сэргээх, чанар байдлыг дүйцүүлэн сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зааснаас бусад нэмэлт арга хэмжээг орон нутгийн удирдлагатай тохиролцон тусгаж болно” гэж өөрчлөх	Байгаль орчныг нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг дан ганц гэрээгээр тохиролцох боломжгүй юм. Учир нь тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОНБУ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан бүх арга хэмжээг гэрээнд заасан эсэхээс үл хамааран хэрэгжүүлэх ёстой. Иймд дээрх баримт бичигт зааснаас бусад нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх асуудлыг л гэрээгээр тохиролцож болох юм.
----	------	--	---

Хуулийн төслөөс хасах заалт

№	Зүйл заалт	Санал	Тайлбар үндэслэл
1.	37.2	Заалтыг бүхэлд нь хасах	Хуулийн төслийн 31.4 дэх заалттай давхардсан байна.
2.	38.2	Заалтыг бүхэлд нь хасах	38.1 дэх заалттай нэгтгэх саналыг өмнө гаргасан болно.
3.	55	Заалтыг бүхэлд нь хасах	Хаалтын зардлыг жишиг байдлаар тогтоох боломжгүй юм. Учир нь байгаль орчныг нөхөн сэргээх зардал нь зөвхөн уурхайн үйл ажиллагааны цар хүрээ, эрсдэлийн түвшнээс бус тухайн бүс нутгийн экологийн онцлог шинж чанараас бас хамаардаг. Өөрөөр хэлбэл, ижил төрлийн үйл ажиллагааг, ижил технологийн дагуу явуулж байгаа боловч хүрээлэн буй орчинд учруулах нөлөөлөл, түүнийг нөхөн сэргээхэд гарах зардал нь харилцан адилгүй юм. Ийм ч учраас төсөл тус бүр дээр байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж, байгаль орчныг хамгаалах зардлыг тодорхой стандарт, аргачлалын дагуу тусгайлан тооцдог.

- Уул уурхайн тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн гишүүн М.Дагва, Д.Жавхланболд (НҮБ-ын эрдэс баялгийн зөвлөх), төрийн бус байгууллагуудаас А.Оюунчимэг (Булаг шанд, гол мөрний эхийг хамгаалах сан), Г.Төмөрмөнх (Ногоон соёл иргэншил сан), Н.Баярсайхан (Хил хязгааргүй алхам), Н.Наранцэцэг, Н.Отгонсүрэн (Байгаль эхийн аврал сан), С.Цэндбаатар (Үндсэн уртраг), С.Цэрэнпүрэв, М.Солонго (Захиргааны шинэ санаачиг), Б.Баярмаа, Б.Баттуяа (Хөвсгөл далайн эзэд), Д.Сүхгэрэл (Оюу толгойн хяналт), Ч.Энхжаргал (Зориг
- Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2, 45 дугаар зүйлийн 1.1 болон Газрын тухай хуулийн 55 дугаар зүйл
- Газрын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалт сан), Ц.Бадам, Д.Жамъян (Дарцагт хайрхан био эко), Д.Үүрийнжин (Шинэ суурьшил, эрүүл аюулгүй орчин), С.Хандсүрэн (Монголын байгаль орчны мэргэжилтнүүдийн холбоо), С.Наранцогт (Туулын хар шугуй), М.Чинзориг (МБОИЗ), Ц.Отгонсүрэн (Ил тод байдал сан), А.Цэнгэлсайхан (Монголын байгаль орчны нөхөрлөлүүдийн холбоо), Г.Оюунтуяа (Хэрэглэгч сан), Я.Цэрэнханд (Ангир нүдэн мөндөөхэй), С.Нинжин-Аюуш (ШУТИС-ГУУС), Э.Энх-Оргил (Литопр ХХК), Л.Долгормаа (Хариуцлагатай уул уурхайн санаачилга), Х.Сувд (Урагш дэвших холбоо), Д.Сарантуяа (Татварт иргэний хяналт), Д.Отгонцэцэг (Онон, Улз голынхон хөдөлгөөн), хэвлэл мэдээллийн байгууллагаас Г.Идэрхангай (Mongolia mining journal) ажиглагчаар Т.Булган (SESMIM төслийн зөвлөх.

Дугаарыг эрхэлсэн:
Д.Эрдэнэчимэг, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn